ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 11 сарын 11 өдөр Дугаар 19/07 Арвайхээр сум

Ойгоос 2027 онд бэлтгэх модны хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, “Ойгоос 2027 онд бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Сайдын 2026 оны А/669 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2027 онд ойгоос бэлтгэх модны хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын ойн сангаас бэлтгэх модны хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аж ахуйн нэгж, нөхөрлөл, иргэдэд ахуйн зориулалтаар бэлтгэх модыг тогтоосон хэмжээнд багтаан сумын нутаг дэвсгэрт бэлтгэх модны хуваарь батлуулах, ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах, эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг ой бүхий сумдын Засаг дарга, Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт даалгасугай.

3.Зөвшөөрөл олгох, шаардлагатай эрхийн бичгээр хангаж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Байгаль орчны газар (Т.Эрдэнэбаяр), Бат-Өлзий сумын Засаг дарга (Н.Орхонтуул), Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт үүрэг болгосугай.

4.Төв суурин газруудын айл, өрхийн хэрэгцээт түлээний модыг төвлөрсөн журмаар Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрээс 2027 онд бэлтгэх модны хуваарьт багтаан бэлтгэж нийлүүлэхийг Бат-Өлзий сумын Засаг дарга (Н.Орхонтуул), Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт даалгасугай

ДАРГА Т.НАРАНГАРАВ

ИТХ/nuuts2026/1.togtool/togtool.doc

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 11 дүгээр сарын 11 -ний өдрийн
19/67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРЭЭС 2027 ОНД ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ

	Сумын нэр	Модны төрөл		Ойгоос мод бэлтгэх тоо хэмжээ			Ойгоос мод бэлтгэх нийт талбайн хэмжээ (га)	Үүнээс			Ойн орлого
		Шинэс,	Хуш	Хэрэглээ(м3)	Түлээ (м3)	Нийт (м3)		Цэвэрлэгээний огтолт	Арчилгааны огтолтоор	Ой цэвэрлэгээний ажлаар	
1.	Бат-Өлзий	15870	100	3320	12650	15970	173	25	10	138	90000000
2.	Зүүнбаян-Улаан	2600		300	2300	2600	15	5		10	15000000
3.	Уянга	2120		120	2000	2120	10	0		10	12000000
4.	Хужирт	3200		400	2800	3200	15	5		10	15000000
5.	Хархорин	500		0	500	500	0	0		0	3000000
	Дүн	24290	100	4140	20250	24390	213	35	10	168	135000000

--- oOo ---



Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн
19/.. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
107

ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ОЙН САНГААС БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ

д/д	Сумын нэр	Модны төрөл, зориулалт		Ойн цэвэрлэгээний огтлолт	Ойн цэвэрлэгээний ажил	Ойн орлого
1.	Бат-Өлзий	Шинэс	Хэрэглээ	600 м3	400 м3	12000000
			Түлээ	300	400 м3	2100000
			Талбай	20 га	25 га	-
2.	Хархорин	Шинэс	Хэрэглээ	-	200	2400000
			Түлээ	-	400	1200000
			Талбай	-	5 га	-
Дүн			Нөөц	900	1400	17700000
			Талбай	20	30	

--- oOo ---